



169

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 64.

Улаанбаатар хот

Жендерийн салбар зөвлөлийн
бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай

“Жендерийн эрх тэгш байдлын тухай” Монгол улсын хуулийн 19.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Салбар зөвлөлийн жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэхийг жендерийн салбар зөвлөлийн дарга (Ж.Хатанбаатар) -т даалгасугай.
3. Эрүүл мэндийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 135 тоот “Жендерийн салбар зөвлөл байгуулах тухай” тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

001763

Эрүүл мэндийн сайдын 2013
оны 03 сарын 26-өдрийн 64 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

**Эрүүл мэндийн яамны дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар
зөвлөлийн бүрэлдэхүүн**

- Зөвлөлийн дарга: ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
- Орлогч дарга: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: БХЗГ-ын Нөхөн үржихүйн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
БТГ-ын Салбарын аюулгүй байдал, эрсдлийн удирдлагын бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
БТГ-ын СЭЗХ салбарын ерөнхий нягтлан
- ТЗҮГ-ын Салбарын хүний нөөцийн хуваарилалт, байршуулалтын бодлого хэрэгжилтийн зохицуулга хариуцсан мэргэжилтэн
- ТЗҮГ-ын Эрүүл мэндийн байгууллагын хөгжлийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- ХШҮДАГ-ын эмнэлгийн тусlamжийн хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга
Д. Мөнхөө
Жендерийн шинжээч (тохиролцсоноор)
- Б.Оюунгоо
ЭМШУИС-ийн сургалтын бодлого зохицуулалтын албаны ахлах арга зүйч, АУ-ны доктор (тохиролцсоноор)
- Б.Оюун НҮБ-ын ХАС-ийн жендерийн асуудал хариуцсан хөтөлбөрийн ажилтан (тохиролцсоноор)

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
03 сарын 06.. ёдрийн 64.. тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

171

Эрүүл мэндийн яамны дэргэдэх жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эрүүл мэндийн яамны дэргэдэх жендерийн салбар зөвлөл нь (цаашид салбар зөвлөл гэнэ) Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хурээнд ажиллана.
- 1.2. Салбар зөвлөл нь эрүүл мэндийн салбарын бодлого, хүний нөөцийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, төсвийг жендерийн мэдрэмжтэй болгоход зөвлөх чиг үүрэг бүхий, Жендерийн үндэсний хороонд ажлаа тайлагнадаг орон тооны бус нэгж байна.
- 1.3. Салбар зөвлөл нь жилээр ажлаа төлөвлөж хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллана.
- 1.4. Жилийн ажлын төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөг Жендерийн Үндэсний Хороонд жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан хүргүүлнэ.
- 1.5. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Гишүүдийн 50-иас дээш хувь нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэй гэж тооцно. Шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар гаргана.
- 1.6. Салбар зөвлөлийн хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, дарга хянаж гарын үсэг зурна.
- 1.7. Салбар зөвлөл нь хэлэлцсэн асуудлаар санал, зөвлөмж, дүгнэлт гаргана.
- 1.8. Салбар зөвлөлөөс гаргасан санал зөвлөмжийг харьяа байгуулагуудад албан тоотоор хүргүүлнэ.
- 1.9. Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор мэргэжлийн бусад байгууллагаас мэргэжилтнүүдийг урьж оролцуулж болно.

- 1.10. Салбар зөвлөл нь Эрүүл мэндийн салбарын жендерийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор гаргаж, дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор Жендерийн Үндэсний хороонд хүргүүлнэ.
- 1.11. Эрүүл мэндийн яамны газар хэлтэс, орон тооны бус зөвлөлүүд нь салбар зөвлөлтэй чиг үүргийн дагуу хамтран ажиллана.

Хоёр. Салбар зөвлөлийн чиг, үүрэг

- 3.1. Эрүүл мэндийн салбарын бодлого, хүний нөөцийн төлөвлөлт, хөтөлбөр төслийг жендерийн мэдрэмжтэй болгоход арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 3.2. Эрүүл мэндийн салбарын эрхэүйн баримт бичгүүдэд жендерийн эрх тэгш байдлыг хангасан талаар дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт гарган удирдлагын зөвлөлд шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулна.
- 3.3. Эрүүл мэндийн яамны эрхлэх ажлын хүрээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийн нэгдсэн сан бурдуулэх үйл ажиллагааг аргазүйн удирдлагаар хангана.
- 3.4. Жэндэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой асуудлаар эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангана.
- 3.5. Эрүүл мэндийн салбарт шаардлагатай жендерийн тэгш байдлын судалгаа, дүн шинжилгээний ажлыг гүйцэтгүүлэх байгууллагыг сонгон шалгаруулна.
- 3.6. Эрүүл мэндийн салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тухай тайланг гаргана.
- 3.7. Эрүүл мэндийн салбарын төсвийн жендерийн мэдрэмжтэй болгох асуудлаар санал оруулж, газар хэлтэстэй хамтран ажиллана.
- 3.8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн бодлогод хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах асуудлаар санал зөвлөмж өгнө.
- 3.9. Эрүүл мэндийн салбарт эрэгтэй эмэгтэй хүмүүсийн онцлог хэрэгцээнд зориулсан өвөрмөц үйлчилгээ бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

- 3.10. Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулахад хамтран ажиллана.

Гурав. Салбар зөвлөлийн эрх

- 3.1. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар явуулж буй үйл ажиллагаатай танилцах, энэ чиглэлийн хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, түүнтэй холбогдсон асуудлаар Эрүүл мэндийн сайдын болон удирдлагын зөвлөлд санал, дүгнэлт оруулна.
- 3.2. Жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн бодлого үйл ажиллагааны талаар мэргэшсэн шинжээчдийг бэлтгэх, давтан сургалтанд хамруулах талаар санал боловсруулж шийдвэрлүүлнэ.
- 3.3. Жендерийн эрх тэгш байдлыг хангахтай холбогдсон арга хэмжээний зардлыг эрүүл мэндийн салбарын төсөвт тусгуулах санал боловсруулж шийдвэрлүүлнэ.

